

**СҮХБААТАР АЙМАГ СҮХБААТАР СУМ ЭРВЭН
ХОШУУНЫ ОВОО ТӨМӨР ЦАЙРЫН ХҮДРИЙН ИЛ
УУРХАЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**

/Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл MV-012328 /

/Регистрын дугаар: 5463599/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-н ахлах шинжээч

Ц.Жаргалнэмэх

Биелэлтийг тайлагнасан:

“Каскейд майнинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал

М.Алтангэрэл

Ерөнхий инженер

Х.Отгондаш

2022 он

АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга
 - Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл
 - Байгаль орчны менежментийн тайлангийн гол зорилго
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
5. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт
6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
7. Осол эрсдэлийн менежментийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр төлөвлөгөөний биелэлт
12. Орон нутгийн хамтын ажиллагаа
13. Нэгдсэн зардал
14. Хавсралт

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

- Каскейд Майнинг” ХХК-ний Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших MV-012328 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Эрвэн хошууны овоо төмөр-цайрын хүдрийн ордыг ил уурхайн аргаар олборлох” төсөл

Төсөл хэрэгжүүлэх ажсахуйн нэгж, байгууллагын нэр:

- “Каскейд Майнинг” ХХК
- Улсын бүртгэлийн дугаар: 9019058053
- Регистрийн дугаар: 5463599
- Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-012328

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

- УБ хот,СБД, 1-р хороо, Олимпийн гудамж, 9-р байр,
- Утас: 99981302

Төслийн товч тодорхойлолт:

“Эрвэн хошууны овоо төмөр, цайрын MV-012328 тоот тусгай зөвшөөрлийн талбайн төмөр цайрын хүдрийн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн хурлын ХХ-19-04 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан, АТГИГ-ын даргын 2020 оны 11-р сарын 27-ны өдрийн н/119 тоот тушаалаар төмрийн хүдрийн нөөцийг бодитой зэргээр 71,291.0 тн, боломжит зэрээр 241,602.0 тн, төмрийн овоолгын нөөцийг боломжтой зэргээр 113,254.0 тн, төмрийн баяжмалын овоолгын нөөцийг боломжтой зэргээр 6530.0 тн, цайрын хүдрийн нөөцийг бодитой зэргээр 8930 тн, боломжтой зэргээр 9794 тн, цайрын хүдрийн овоолгын нөөцийг боломжтой зэргээр 12,423 тн нөөцтэй гэж бүртгэгджээ.

- Төсөлд ашиглалтын үеийн хаягдал төмрийн хүдэр болон цайрын хүдрийг 3.91% буюу 4685 тн, бохирдол 9.78% буюу 11 717 тн байхаар тооцож геологийн бодитой В зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В’ нөөцөд шилжүүлэн тооцсоноор төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн нөөц нийт 112 356 мян.тн, цайрын хүдрийн үйлдвэрлэлийн нөөц нийт 14.48 мян.тн байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 127.8 мян.тн хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 63 мян.тн хүдэр олборлоно.

- Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших MV-012328 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрвэн хошууны овоо төмөр, цайрын ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн ТЭЗҮ-ийг “Прожект майнинг” ХХК боловсруулсан байна.

Төслийн зорилго:

- Нөөцийг иж бүрэн ашиглах, техник технологийн шийдлийг оновчтой зөв гаргах, нөхөн сэргээлт, ажиллагсдын хөдөлмөр хамгаалал эрүүл мэнд, орон нутаг дэд бүтцийн хөгжилд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулах

Төсөл хэрэгжих үе шат:

- МУ-012328 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 3 жилийн хугацаанд хэрэгжинэ.


Төслийн байршил:

Эрвэн хошууны овоо төмөр-цайрын хүдрийн орд нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах бөгөөд Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотоос 110 км, Сүхбаатар сумаас зүүн хойш 54 км, Чойбалсан хотоос баруун урагш 120 км, Хэнтийн Сүмбэр сумыг дайран өнгөрөх мянганы замаас урагш 20 гаруй км, Сүхбаатар-Дорнод аймгуудыг холбосон өндөр хүчдэлийн шугамаас 20 км зайд оршино. Талбайн хэмжээ: 77.75 гектар
Талбайн байр зүйн зургийн нэрлэлбэр: L-50-52

Хүснэгт 6. Талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	114° 5' 56.36''	47° 13' 15.82''
2	114° 5' 56.36''	47° 13' 41.83''
3	114° 5' 10.37''	47° 13' 41.83''
4	114° 5' 10.37''	47° 13' 15.82''


Зураг 4. Төслийн талбайн байр зүйн зураг




1.1. Төслийн талбайн байгаль орчны төлөв байдал

Ашиглалт явуулах талбай нь газарзүйн байршлаар Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших ба Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотоос 110 км, Сүхбаатар сумаас зүүн хойш 54 км, Чойбалсан хотоос баруун урагш 120 км, Хэнтийн-Сүмбэр сумыг дайран өнгөрөх мянганы замаас урагш 20 гаруй км, Сүхбаатар-Дорнод аймгуудыг холбосон өндөр хүчдэлийн шугамаас 20 км зайд оршино. Энэхүү төмрийн илрэл нь Төмөртийн овооны цайрын уулын баяжуулах үйлдвэрээс зүүн хойш 80 км, Арын нуурын зэс мольбдений ордоос зүүн тийш 10 км -т оршино.

Газрын гадаргуу: Эрвэн хошууны овоо төмөр, цайрын орд нь Монгол-Агнуурын атираат бүсийн зүүн Монголын геосинклиналь өргөгдлийн буюу Говь-Алтай-Сүхбаатарын бүтэц хэлбэршлийн бүсийн хэмжээнд байрлана. Энэхүү төмрийн илрэл нь Төмөртийн овооны цайрын уулын баяжуулах үйлдвэрээс зүүн хойш 80 км, Арын нуурын зэс мольбдений ордоос зүүн тийш 10 км -т оршино. Уг илрэл нь Дорнод Монголын металлагени их мужийн Сүхбаатарын холимог төмөрлөгийн хүдрийн дүүрэгт буюу Арын нуур, Мухар эргийн овоо, Эрвэн хошууны овоо гэсэн хүдрийн зангилаанд байрлана. Эрвэн хошууны овоо уурхайн талбай нь тал хээрийн бүс дахь Сүхбаатар оройтой намхан уул, тэгшэвтэр тал бүхий бүсэд хамаарна. Талбайн үнэлэхүй өндөр 850-950м-ийн хооронд хэлбэлзэх ба хамгийн өндөр уул нь талбайн урд хэсэгт орших Цагаан өндөр (1047.0м), хамгийн намхан цэг нь талбайн зүүн хэсэг дэх Холбоогийн говь (840 м) бөгөөд талбайн ихэнх хэсгийг (70%) тал, хөндий эзэлнэ. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 902.5-964.3 метрийн үнэмлэхүй өндөрт байрлах ба газрын гадаргын хэвгий буюу налуу төслийн талбай нь районд 1.42-6.97 (градус)-т байна. Одоогийн байдлаар олборлолтын явцад ил уурхайн гүн нь 40 орчим метрт хүрсэн байгаа ба нийт 32.6 орчим га талбай эвдрэлд өртсөн байна.



Зураг 2. Талбай орчмын үнэмлэхүй өндөр



Зураг 3. Талбайн гадаргын налуу буюу хэвгий

Усан сүлжээ: Талбайн хэмжээнд усан сүлжээ дунд зэрэг хөгжсөн бөгөөд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг. Түр зуурын борооны уснаас үүссэн тогтмол нуурууд, гар болон өрөмдмөл худгууд талбайн хэмжээнд элбэг тохиолдоно. Эдгээр худгуудын ихэнх нь техникийн болоод ундны хэрэгцээг хангадаг. Худгийн ундарга 150-800 л/ц хүрэх ба Жавхлант овооны худгийн ундарга 1650-1800 л/ц гэж тогтоосон байдаг.

Цаг агаар: Төслийн талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилд унах хур тунадасны хэмжээ 205-220 мм орчим бөгөөд хур тунадасны ихэнх нь 7,8,9-р саруудад ихэвчлэн уулархаг нутгаар унадаг. Дэлхийн дулааралтай холбоотойгоор талбайн хэмжээнд сүүлийн жилүүдэд жилд унах хур тунадасны хэмжээ 30-50 мм-ээр багасаж байгаагийн улмаас орон нутгаар гандуу болж өвс ургамлын гарц эрс муудаж байна. Жилийн дундаж температур +6.40С, хамгийн дулаан улирал нь 7,8-р сард +350С, хамгийн хүйтэн үе нь 1-р сард -250С хүрдэг. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба салхины хурд дунджаар 1-2м/с байх ба хамгийн их салхи шуургатай улирал нь 5-6 сард болдог. Энэ үед салхины хурд 10 м/с-ээс дээш салхилна. Зарим жилүүдэд тухайлбал 2008 онд байгалийн гамшиг болоход цасан болон шороон шуурга 5-6 хоног үргэлжилсэн ба салхины хурд 25-28м/с хүрсэн тохиолдол тэмдэглэгдсэн.

Хөрс, ургамал ба ан амьтан: Хөрсний хувьд говь, хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Хөрс үүсэхэд хур тунадас, салхи ихээхэн үүрэгтэй. Салхи нь хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж ууршилтыг ихэсгэснээр хөрс хуурайшихад нөлөөлөөд зогсохгүй хөрсний өнгөн хэсгийг хийсгэж нүүлгэн хөрс эвдэхэд ихээхэн нөлөөтэй. Хур бороо элбэг үед ургамлын бүрхэвч сайжирч хөрсний эвдрэл үүсэх нөхцөлийг багасгана. Тэгш өндөрлөг газруудад бор саарал, саарал хөрс зонхилж, мараалаг борзон хайрга, чулуун хуягаар зарим газраа бүрхэгдэнэ. Хонхор хотгор газруудаар хужир тойром, мараалаг хөрс элбэг тархана. Зарим газруудын ар хормой бэлээр элсэрхэг хөрс зонхилно.

Ургамал зүйн хувьд тал хээрийн ургамал зонхилон ургана. Талбайн хэмжээнд ургамлын бүрхэвч сайн хөгжсөн бөгөөд говирхог нутгаараа баглуур, дэрс, бударгана зэрэг бутархаг ургамал, талархаг газраараа хиаг, таана, агь, хөмүүл ургана. **Ан амьтан.** Судалгааны талбайн орчимд чоно, үнэг, хярс, өмхий хүрэн зэрэг араатан, цагаан зээр, хар сүүлт зэрэг сүүн тэжээлтэн, хулгана, зурам, тарвага зэрэг мэрэгч амьтад амьдардаг. Нугас, галуу, хун г.м нүүдлийн шувуудаас гадна бүргэд, тас, шонхор, тагтаа, болжмор. Хараацай зэрэг шувууд амьдардаг.

Цахилгаан хангамж: Эрвэн хошууны овоо төмрийн хүрийн ордыг ашиглах уурхайн ашиглалтын жилүүдэд цахилгаан эрчим хүчний үүсгүүр нь Чойбалсан-Баруун-Уртын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дизель станцын үр ашигтай хувилбар байх юм.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Энэ нутагт Халх Монголчууд нутагшин амьдрах ба үндсэн эрхлэх аж ахуй нь мал аж ахуй болдог. Сүхбаатар сумын төвд сумын захиргаа, хүн эмнэлэг, холбоо, дунд сургууль, шатахуун түгээх станц, дэлгүүр, хилийн цэргийн отряд, Мобикомын станц, дизель станц, соёлын төв зэрэг соёл үйлчилгээний байгууллагууд ажилладаг. Одоогийн байдлаар судалгааны талбайн баруун хойно орших Тал булгийн нүүрсний уурхайд олборлолтын ажил явагдаж байна. Хүн амын ихэнх нь халх үндэстэн бөгөөд тэдгээр нь гол төлөв мал аж ахуй эрхлэхээс гадна сумын төвд төрд алба хаах эсвэл, хувийн хэвшлийн болон улсын үйлчилгээний газарт ажиллаж амьдардаг. Сүхбаатар сум нь аймгийн төв болон бусад сумуудтай утсан харилцаагаар болон түүнээс гадна Мобикомын сүлжээнд хамрагдсан тул холбоо харилцааны хувьд найдвартай. Сумын төв болон хөдөөгийн малчид сансрын антены тусламжтайгаар телевизийн үйлчилгээг авдаг бөгөөд тэдгээртэй шороон замаар холбогдоно.


Дэд бүтэц: Судалгааны талбай нь дэд бүтэц сайн хөгжсөн дүүрэгт байрлах ба уг талбай нь Улаанбаатар хотоос 650 км, Баруун-Урт хотоос 110 км, Сүхбаатар сумаас зүүн хойш 54 км-т байрлах ба хоорондоо шороон замаар холбогдоно. Мөн Тал булгийн нүүрсний уурхайгаас 120 км, Чойбалсан-Баруун-Уртын өндөр хүчдэлийн шугамаас 20 км, Чойбалсан хотын Баянтүмэнгийн төмөр замын өртөөнөөс 120 км зайд байрлаж байгаа нь дэд бүтцийн таатай орчинг бүрдүүлж байгаагийн дээр судалгааны талбайгаас хойш 30 орчим км зайтай Мянганы зам тавигдахаар төлөвлөгдөж байгаа нь тус ордын хувьд зам харилцаа, дэд бүтцийг хөгжүүлэх бүрэн боломжтойг харуулж байна. Дээрх сум, уурхайн төвүүд нь төвийн эрчим хүчний өндөр хүчдэлийн шугаманд холбогдсон байдаг.

1.2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Эрвэн хошууны овоо төмөр цайрын хүдрийн ордыг ашиглах төслийн баримт бичигт туссан гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг дээр тодорхойлсон бөгөөд үүнд үндэслэн давхцуулан зураглах арга, Магадлан жагсаах аргыг ашиглан байгаль орчны шинжилгээ хийж, гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг тодорхойлов. Эрвэн хошууны овоо төмрийн хүдрийн уурхай нь 2007-2010 онд уулын ажил явуулж 375.3 мян.тн, 2017-2018 онд 137.2 мян.тн хүдэр олборлосон үзүүлэлттэй байдаг. 2011-2017 онд хуурай баяжуулах үйлдвэрийн эвдрэл гэмтэл болон хөрөнгө оруулалт, бусад асуудлын улмаас уурхайн ажил түр зогссон. Олборлолтын явцад 2006 онд улсын нөөцөд бүртгүүлсэн нөөц батлагдахгүй, гүнрүүгээ явах тусам төмрийн хүдрийн гарц багасаж нөөцийн зөрүү улам ихсэж байсан бөгөөд 2018 оны эцсийн байдлаар нөөцийн үнэмшил 22 хувьтай болж буурсан байна. Иймд “Каскейд Майнинг” ХХК нь MV-012328 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2011-2012, 2018 онуудад нэмэлт хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн ба энэхүү үр


дүнгээр тайланг боловсруулан Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байна.

“Эрвэй хошууны овоо” төмөр- цайрын ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн баримт бичигт туссан гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг дээр тодорхойлсон бөгөөд үүнд үндэслэн давхцуулан зураглах арга, Магадлан жагсаах аргыг ашиглан байгаль орчны шинжилгээ хийж, гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг тодорхойлов. Ил уурхайн оновчлолоор үүссэн хүрээнд 345.1 мян.тн хөрс хуулж, 126.8 мян.тн хүдэр олборлохоор байна. Иймд энэ хүрээнд олборлох, баяжуулах үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг тооцоолох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зөвлөмж боловсруулах нь энэхүү байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зорилго юм. Дараах зурагт уурхайн төлөвлөлтийг хиймэл дагуулын зураг дээр тайлбарлан оруулав.



Зураг 20. Уурхайн объектуудыг харуулсан хиймэл дагуулын мэдээ

Өмнөх уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа болон дэд бүтцээс нийт 32.6 га талбай өртсөн байна. Нэмэлт олборлолтын явцад уурхайд нийт 5.0 га талбайн газрын хэвлийд 58 м гүн, 220 м урт, 240 м өргөнтэй ухаш үүснэ. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тогтоохдоо БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан нөлөөлөл буурах функцийг ашигласан болно. Нөлөөллийн эх үүсвэрүүдийн тэгш хэмт цэгээс хүчтэй нөлөөлөл 0-1100 м зайд, дунд зэргийн нөлөөлөл 1100-1250 м зайд, бага нөлөөлөл 1250-2650 м зайд тус тус үүсэх магадлалтай юм.



Зураг 21. Төслийн нөлөөллийн бүс

БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан үзүүлэлтээр байгаль орчны шинжилгээ хийж үр дүнг дараах хүснэгтэнд үзүүлэв.

Байгаль орчны шинжилгээ

№	Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд	Тийм	Үгүй
1	Газрын гадаргын хэв шинжид гарах өөрчлөлт	+	
2	Газар ашиглалтын өөрчлөлт	+	
3	Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх	+	
4	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх	+	
5	Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх	+	
6	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явагдах эсэх	+	
7	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх		+
8	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх	+	
9	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус/ гарах эсэх	+	

Орчны бохирдол			
10	Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа төрлийн бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгарах эсэх	+	
11	Дуу шуугианы нөлөө	+	
12	Чичиргээний нөлөө	+	
13	Дулааны нөлөө	+	
14	Цахилгаан соронзон долгионы нөлөө	+	
15	Цацрагийн нөлөө		+
16	Гадаргын болон газрын доорх усанд бохирдуулагч бодис нэвчих үед усны бохирдол үүсэх эсэх	+	
Эрсдэлийн үнэлгээ			
17	Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үүсэх эрсдэл	+	
18	Байгаль орчинд үүсэх эрсдэл	+	
Нийгэм-эдийн засаг			
19	Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор нийгэмд тодорхой өөрчлөлт гарах эсэх	+	
20	Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх	+	
21	Бизнесийн таатай орчин бүрэлдэх	+	
22	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх	+	
23	Шинээр ажлын байр бий болох	+	
24	Орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	+	
25	Хөдөлмөр эрхлэлтэд өөрчлөлт гарах	+	
26	Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг зэрэгт сөргөөр нөлөөлөх		+
27	Тухайн орон нутгийн оршин суугчдын дасан зохицсон амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөх	+	
28	Хөгжлийн хэтийн төлөвлөгөө, тухайн үед орон нутагт хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, бусад хүчин зүйлс байгаа эсэх	+	
29	Байгаль орчны бохирдол, доройтол үүсгэж болзошгүй зам, тээврийн үйл ажиллагаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд явагдах эсэх	+	

1.3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Байгаль экосистемийн өөрчлөлт: Эрвэн хошууны төмрийн хүдрийн ил уурхайн хүрээнд нийт 63.4 мян.тн хүдэр олборлож, 127.8 мян.т хөрс хуулна. Хөрс хуулах, олборлолтын ажлын технологийн үндсэн процесс нь өрөмдлөг-тэсэлгээ, ухаж ачих, тээвэрлэх /дотоод болон гадаад/ гэсэн дэд процессуудаас бүрдэнэ. Иймд геологийн тогтцыг эвдэж өөрчлөх, газрын нөөц баялгийг ашиглах явцад бий болох ихэнх нөлөөлөл нь шууд нөлөөлөлд хамаарна. Тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох геологийн тогтоц, хөрс, бэлчээрийн ургамалд шууд нөлөөлж буй бөгөөд эдгээр нь урт хугацааны хүчтэй нөлөөлөлд хамрагдах бөгөөд ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Түүнчлэн зэрлэг ан амьтад үргэн дайжих, тоос шороо дэгдэн бичил уур амьсгалын нөхцөл богино хугацаагаар бага зэрэг өөрчлөгдөж болох юм. **Байгалийн баялаг, нөөц ашиглалт:** Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй юм. Иймд Монгол улсын Газрын хэвлийн хууль, Ашигт малтмалын хууль, айгаль хамгаалах хуульд заасан арга хэмжээг

хэрэгжүүлэх, байгалийн баялгийг алдагдал хаягдалгүй бүрэн ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүр үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж байх үүрэг уг уурхайд ногдож байгаа юм.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Төслийн үйл ажиллагааны үр дүнд уурхайн ашиглалтын давхаргад шатах тослох материал, тэсрэх бодисын хэрэглээтэй холбоотойгоор газрын доорх усны чанарт өөрчлөлт орох магадлалтай юм. Энэ нөлөөлөл нь урт хугацаанд /газрын доорх усанд нэвчсэн шатах тослох материалын задрал нарны энерги байхгүй учир удаан байна /буцалттай / хэдийн задрал удаан боловч тодорхой хугацааны дараа ус цэвэрших боломжтой /удаан хугацаанд шатах тослох материалаар бохирдсон уснаас мал, амьтан, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үр дагавар нь дунд зэрэг учир эрчим нь дунд зэрэг байна. Тэсрэх бодисын ашиглалттай холбоотой хүний эрүүл мэндэд /тэсрэх бодистой харьцаж байгаа ажилчид/ сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай /эрсдэлийн үнэлгээний хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү/. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор: Байгалийн тогтоц буюу газрын гадаргын хэлбэршилд сөрөг нөлөөлөл үзүүлэх бөгөөд энэ нөлөөлөл нь тусгай зөвшөөрлийн талбайтай харьцуулбал бага хэдийн ч байгалийн бус уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас 5.0 га талбай ил уурхайн ухаш, 21.66 га талбай хөрсний овоолго, 2.9 га талбай технологийн зам, 3.04 га хүдрийн агуулах, бусад дэд бүтцийн объект зэрэг үүссэнээр тухайн нутгийн ландшафтын хүчтэй өөрчлөлтөд орсон байна.

Нийгэм, эдийн засаг:

Уг төсөл хэрэгжсэнээр ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах, нийт 157 хүнийг ажлын байраар хангана, тэдний амьжиргаанд тус нэмэр болж буй сайн талтай юм. Ашиглалтын хугацаанд цалинд 1705.0 сая, жилд дунджаар 569.0 сая төгрөг тусгагдсан байна. Уурхайн ажилд чын сарын дундаж цалин 1.32 сая төгрөг байна. Ашиглалтын хугацаанд 3205.2 сая.төг улс орон нутгийн төсөвт оруулахаар байна. Эдгээр нь шууд бөгөөд богино хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл: Тус төмөр цайрын хүдрийн уурхай нь хуурай хээрийн экосистем бүхий нутагт байрлах тул төмрийн хүдэр олборлох технологийн бүхий л үе шатанд тоос шороо дэгдэхээс хамгаалах, олон салаа зам гаргах зэргээр хөрсний эвдрэлийг ихэсгэхээс болгоомжлох шаардлагатай болно. Ил уурхайн аргаар байгалийн эрдэс баялгийг олборлодог уурхайн хувьд онц аюултай хүчтэй салхи, уруйн үер (хүчтэй аадар борооны дараах) зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж болох талтай.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал:

Эрвэн хошууны төмөр цайрын хүдрийн орд газрыг ашиглах ТЭЗҮ-ийг Монгол улсын Ашигт Малтмалын Газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар баталгаажуулсан нь технологийн хувьд хамгийн оновчтой хувилбар гэж үзсэний баталгаа болох юм. “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д заагдсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор энэ чиглэлийн мэргэжилтэн авч ажиллуулан, улирал тутам ил уурхайд ажиллах ажилчдын дунд сургалт явуулж шалгалт авч байхаар ТЭЗҮ-д тусгасан байна. Мөн БОННУ-ний тайлангийн эрсдэлийн үнэлгээний хэсэгт тодорхойлсон аюул ослын үнэлгээний үр дүн, Монгол улсын хууль эрхзүйн баримт бичгийн заалт бүрийг хангаж ажиллах хэрэгтэй.

Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал:

Тус уурхайн олборлолтын үйл ажиллагаанд тэсрэх бодис, тээвэрлэлт, тээврийн хэрэгсэлд ШТМ ашиглана. Тэсрэх бодисын агуулахыг зөв газар, аюулгүй ажиллагааны заавар, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдолд химийн бодис алдагдах магадлалтай, ШТМ-ын хувьд мөн адил юм. Тэсэлгээний материалын хадгалалт хамгаалалтад онцгой анхаарал тавих, түүнчлэн тэсэлгээ хийх, шатах тослох материалыг хадгалах, ашиглах явцад үйлдвэрлэлийн осол аваараас сэргийлэх, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж байх шаардлагатай болно.

Мөн ахуйн хог хаягдлыг зөөх, далдлах, ариутгах зэрэг ажлыг тодорхой хуваарийн дагуу хийж, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж байх нь зүйтэй юм. Уурхайн ухааш, хөрсний овоолго болон бусад барилга байгууламжийн шууд нөлөөлөлд 32.6 м2 талбайн хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөнө.

Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд:

ТЭЗҮ-д тусгаснаар хүдрийг ил аргаар, гадаад овоолго бүхий тээвэртэй ашиглалтын системээр олборлоно. Ил аргаар олборлох үед тэсэлгээ, ухааж ачих процесс, дотоод тээвэрлэлт зэргээс агаар орчинд тоосжилт үүсэх нөлөөлөл үзүүлэхээс гадна 32.6 га талбайн хөрс, ургамал шууд нөлөөлөлд өртөнө. Гадаад овоолгод хурдас чулуулаг овоолох үед болон салхины хурд ихтэй үед тоос агаарт дэгдэнэ. Мөн хөрсний овоолгод 21.66 га талбайн хөрс, ургамал нөмрөг өртөгдөнө. Төмрийн хүдэр баяжуулалтыг хуурай, нойтон соронзон баяжуулалтаар, цайрын хүдэр баяжуулалтыг флотацийн аргаар гүйцэтгэнэ. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх боломжит нөлөөллийг тодорхойлохдоо магадлан жагсаах арга, давхцуулан зураглах арга зэргийг ашигласан бөгөөд давхцуулан зураглах аргыг математик загварын аргатай хам байдлаар ашиглан шууд болон шууд бус нөлөөлөлд өртөх байгалийн хам бүрдлийг тодорхойлов.

Эдгээр аргаар тодорхойлсон нөлөөллийг тоон хэлбэрт шилжүүлэхдээ Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлалд заасан магадлан жагсаах аргын хувилбарыг нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлоход ашиглав.

Эрвэн хошууны овоо төмөр, цайрын хүдрийн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгалийн хам бүрдэлд үзүүлэх нөлөөллийг эрэмбэлбэл жижиг хөхтөн амьтад, тэдгээрийн амьдрах орчин, хөрсөн бүрхэвч, ургамал нөмрөг, геоморфологийн хэлбэршил, агаарын чанар, усны нөөц, горим орж байна. Төслийн үйл ажиллагааг эрэмбэлвэл хамгийн их нөлөөлөл үзүүлэх хүчин зүйл нь олборлолтын үйл ажиллагаа, гадаад овоолго юм. Мөн дотоод замаар тээвэрлэлт хийх нь гол нөлөөлөл юм. Бусад хүчин зүйл нь уурхайн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг холбогдох стандартын дагуу хийж гүйцэтгэх нөхцөлд хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага байх боломжтой юм.

1.4. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БҮЮУ ТӨСЛИЙН ТОДОРХОЙГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮСЭХ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Эрсдэлийн дүн шинжилгээний матрицын үр дүнгээс төсөл хэрэгжих хугацаанд үүсэж болзошгүй эрсдэлүүд нь ихэвчлэн хүний буруутай үйл ажиллагаанаас үүсэх магадлалтай байна. Байгалийн давагдашгүй хүчин зүйл буюу газар хөдлөлт, үер, аянга цахилгаан, хог

хаягдлаас үүдэлтэй эрсдэлээс нийгмийн эрүүл мэнд, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болон төслийн үйл ажиллагаанд нөлөөлөх өндөр байдаг.

Гал түймрийн аюул, байгалийн давагдашгүй хүчин зүйл болон хүний санамсар болгоомжгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллөөр байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт учирч болох эрсдэл, химийн хортой болон аюултай бодис алдагдаж байгаль орчныг бохирдуулах, тэсэрч дэлбэрэхтэй холбоотой эрсдэл өндөр байна.

Иймд эрсдэлийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

Төслийн үйл ажиллагааг хэвийн байлгахад эрсдэлийг бууруулахад авах арга хэмжээг мөрдөж ажиллавал тус үйлдвэрээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учруулах нөлөө бага байна гэж үзэж байна.

1.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

Тайлангийн зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, аливаа бохирдлын түвшинг хянах, ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээлт хийх, дүйцүүлэн хамгааллын ажлыг гүйцэтгэх зэрэг ажлын дүнг нэгтгэж гарган тайлагнах юм.

Үүнд:

- ✓ Байгаль орчны бүх хууль, тогтоомжуудыг даган мөрдөх;
- ✓ Байгаль орчныг хамгаалах шилдэг аргуудыг үйл ажиллагаандаа бий болгох удирдлагын системийг хэрэгжүүлэх;
- ✓ Бүхий л үйл ажиллагаандаа "багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах" зарчмыг хэрэгжүүлэх;
- ✓ Ажилчиддаа байгаль орчноо хамгаалах хариуцлагыг нь ухамсарлуулан ойлгуулах, энэ тухай явуулах сургалтанд хамруулах;
- ✓ Байгаль орчныг хамгаалах үүргээ цаашид улам идэвхжүүлэх;
- ✓ Байгаль орчныг хамгаалах нь бидний үйл ажиллагааны чухал нэгэн хэсэг юм;
- ✓ Ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжийн мөрдөх хууль, стандартыг хангуулах;
- ✓ Компанийн дотоод дүрэм, журам, горимд байгаль орчныг хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх заалтуудыг багтаах;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний заалтуудыг шат дараатай хэрэгжүүлэх.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 11 бүрэлдэхүүн хэсэгт нийт 44 ажил төлөвлөн биелэлтийг ханган ажиллаа.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
№	Төлөвлөгдсөн ажил	Зардал /төг/	Ажлын биелэлт / тайлбар/	Биелэлтийн хувь
1	Ил уурхайгаас үүсэх тоосжилт	400,000	Уулын ажил зогсолттой байсан тул хөдөлгөөний эрчим бага тул бусад зам талбайнуудад үүссэн сул шороо, туйранг хусах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.	100
2	Хорт хийн ялгарал	Дотоод төсөв	Ажиллаж буй машин хүнд машин механизмыг төлөвлөгөөт үзлэгт хамруулж, уурхайд байрлах засварын цех нь шаардлагатай засвар үйлчилгээг хийж ажиллаж байна.	100
		400,000		

2.2. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
№	Төлөвлөгдсөн ажил	Зардал /төг/	Ажлын биелэлт / тайлбар/	Биелэлтийн хувь
1	Уурхайн орчныг тэмдэгжүүлэх, хил хязгаар тогтоох.	400,000	Ашиглалтын талбайн газруудад хил хязгаарын эргэлтийн цэг, шав тэмдэгийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэв.	100
2	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хянаж явуулах.	-	Уулын ажил зогсолттой холбоотойгоор мөн уурхайн ашиглалтаас гадна талбайд газар шорооны ажил хийгдээгүй.	100
		400,000		

Зураг №1-3 шав тэмдэг



2.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
№	Төлөвлөгдсөн ажил	Зардал /төг/	Ажлын биелэлт / тайлбар/	Биелэлтийн хувь
1	Хуулж авсан шимт хөрсийг технологийн дагуу хадгалах	Дотоод төсөв	Уулын ажил зогсолттой холбоотойгоор 2022 онд шимт хөрс хуулалт хийгдээгүй ба Хуучин шимт хөрсний овоолгын хөрсний овоолгыг стандартын дагуу 4м өндөртэйгөөр хадгалж байна.	100
2	Шимт хөрсний чанарыг алдагдуулахгүй, тоосжилт үүсэх нөхцөлөөс урьдчилан сэргийлж олон наст ургамлын үрээр ургамалжуулах	Дотоод төсөв	Шимт хөрсний овоолгын талбайд олон наст ургамлын үр тарьсан ба ургалтын хувь 50 хувьтай байв.	100
3	Нефтийн бүтээгдэхүүн бүхий хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, бохирдсон хөрсийг тухай бүрд нь цэвэрлэж байх	1,000,000	Техник үйлчилгээнээс гарсан хаягдал тос маслыг Үйлдвэрийн конусан бутлуурын тосолгоонд ашигладаг ба хөрс орчин бохирдохоос сэргийлж тусгай бэлтгэсэн талбайд үл нэвчүүлэх плёнк дэвсэн хадгалаж байна.	100
4	Хаягдлын далангийн бүрэн байдлыг тогтмол шалгах	Дотоод төсөв	АБҮ-г 7 хоног бүр тогтмол хийж бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж байна.	100
5	Ашиглахгүй болсон шороон замыг хаах, нөхөн сэргээх	Дотоод төсөв	Ашиглагдахгүй болсон зам талбайг хаах шаардлагатай газруудад хөмсөг тавих зэрэг ажлыг уурхайн бүсэд хийж гүйцэтгэв.	100
НИЙТ		1,000,000		

Зураг №4-5 Хаягдал тос масло хадгалах цэг



Зураг № 6 шимт хөрсний овоолго

Зураг № 7-8 шимт хөрсний овоолго



2.4. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
№	Төлөвлөгдсөн ажил	Зардал /төг/	Ажлын биелэлт / тайлбар/	Биелэлтийн хувь
1	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Дотоод төсөв	Унд ахуйн усны химийн бодисын шинжилгээг Аймгийн БОХЗ лабораториор шинжлүүлсэн ба мөрдөгдөж буй стандарт хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.	100
2	Цэвэр ус нөөцлөх зориулалтын сав худалдан авч ашиглах.	1,200,000	1 тн цэвэр усны нөөцийн савыг байршуулав.	100
3	Гүний худагт тоолуур тавьж баталгаажуулах.	300,000	Ашиглаж буй усны эх үүсвэрт баталгаажуулалт бүхий тоолуурыг мэргэжлийн байгууллагаар суурилуулан акт үйлдэв. Тоолуурын заалтаар 890м3 усыг ашиглаад байна.	100
4	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	-	2022 онд ашиглах усны дүгнэлтийг Усны газраар гаргуулан дүгнэлтийн дагуу ус ашиглаж байна. /Дүгнэлтийг хавсралтаар оруулав/	100
5	Ус ашиглах зөвшөөрөл авах гэрээ байгуулах	-	Дүгнэлтийг үндэслэн Хэрлэн голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна. /Гэрээг хавсралтаар оруулав/	100
6	Хаягдал усны зөвшөөрөл авах	-		
НИЙТ		1,500,000		

Зураг № 9--10Тоолуурын баталгаажуулалт, суурилуулалт



Зураг № 11-13 Усны нөөц сав, усны дүгнэлт, гэрээ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

Чөлөөтөвчин гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 85 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2022.08.14 № 01/1913
Танай *Х.Болдбаатар* № 26/1913

"КАСКЕЙД МАЙНИНГ" ХХК-Д

Танай байгууллагын 2022 оны 86/2022 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг судалж үзээд Усны тухай хуулийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших ашиглалтын MV-012328 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий "Эрээн Хошууны овоо" төмөр, цайрын ордой ил аргаар ашиглах төсөлд ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Хэрлэн голын сав газрын захиргаанд.
Хавсралт 4 хуудастай.

УСНЫ НӨӨДИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА *Х.Болдбаатар*

163222223

ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ГАРГАХ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Х.Болдбаатар*

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 01 сарын 25-ний өдөр
Дугаар 01
Чөлөөт хот

Нэг, Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын харилцаа 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдөр 181 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хэрлэн голын сав газрын захиргааны өргөсөн 2022 оны 09 дугаар сарын 15-ний өдөр 11 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж

Хэрлэн голын сав газрын захиргааны Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээний асуудал хариуцаж зөвлөх мэргэжилтэн Түвшдэрх овогтой Баатарзүх

Ус ашиглагчийг төлөөлж

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж, 6-р байр, 104 тоот, усны бүртгэлийн дугаар 9019058053, регистрийн 5463299 дугаартай "Каскейд майнинг" ХХК-ийн Ерөнхий менежер Х.Отгонцэнэ нар ус ашиглах тавар тохиролцон өнөгүй гэрээг 1 (нэг) жилийн хугацаатайгаар (2022.08.05-2023.12.31) байгуулав.

Хөр, Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дахь MV-012328 тусгай зөвшөөрлийн дугаартай, 77,75га "Эрээн Хошууны овоо" нэртэй төмрийн хүдэр болон цайрын ордой ил аргаар олборлох зүйлээ ордондоо болон флюидар нутагтаа байгуулах үйлдвэрийн төлөвлөгөөний болон үнэ аман үнд зүйлн харилцаанд усны нөөцийг ашиглаха.

2.2. Ашиглах усны хэмжээ: 92.570 м³/өдөр

2.2.1. унд-ахуйд 23.54 м³/хоног

2.2.2. үндэртэлд 318.3 м³/хоног

2.3. Усны чанар, нарийвца 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагданы дагуу усны зах үсвэр болж хуудас үүрвэл тутам дахь авч шинжилгээ хийгдэн харуу болон дүнлэлтийг Сав газрын захиргаанд ирүүлнэ. Усны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд төвийг хангалт" MNS 900:2018 стандартад шаардлагаг нийцсэн усны үнд ахуйд хэрэглэх шаардлагатай.

2.4. Усны зах үсвэрээр: Үнд ахуй болон үйлдвэрийн төлөвлөгөөний харилцаанд усны тасгийн талбайд байрлах 3 ргс учрагатай 1 ш гуний хугацаа хангана. Тоолууртай, Хуудас №1: 114°06' 41.1" 47°13' 52.64" Уурдлага 3.0 ргс, Баруунга байгууламж: 100м² багтаамжтай эргэлтийн усан сантай, Тонно төмөрөнгийн нар, марс Гүний хуудат CV-21 маррын насос суурилуулсан

2.5. Хажалд усны хэмжээ:

2.5. Ан амьтан болон Ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
№	Төлөвлөгдсөн ажил	Зардал /төг/	Ажлын биелэлт / тайлбар/	Биелэлтийн хувь
1	Биологийн аргаар нөхөн сэргээх талбайд бэлчээрийн идэмжит ургамлыг тарина.	500,000	Шимт хөрсний овоолгын талбайд олон наст ургамлын үр тарьсан ба ургалтын хувь 50 хувьтай байв.	100
2	Нутгийн ан амьтадад биотехникийн арга хэмжээ авч байх.	200,000	Сүхбаатар сумын байгаль орчны байцаагчид 200кг хужир мараа хүлээлгэн өгсөн.	100
НИЙТ		700,000		

Зураг № 14-16 Олон наст ургамалын үр тариалах явц



3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхайн эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, Газрын хэвлийн тухай хууль, Нөхөн сэргээлт хийх журам зааварчилгааг мөрдлөг болгон ажиллаа.

Нөхөн сэргээлтийн арга хэмжээний биелэлт					
Зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Талбайн хэмжээ /га/	Зардал /мян.төг/	Биелэлт	Биелэлтийн хувь
Үйл ажиллагааны явцад үүссэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх.	Техникийн нөхөн сэргээлт	1	4,000,000	Хуучин хүдрийн агуулахын талбайг буцаан дүүргэж, шимт хөрсөөр хучин гадаргууг хэлбэршүүлж техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэв.	100
Хоосон орон зай, ухшийн ирмэгийг хэвгийжүүлэх		3.50	Дотоод зардал	Уурхайн хаалтын дараа хийгдэнэ.	
Ашиглагдсан орон зайг дүүргэх		4.77	Дотоод зардал		
Овоолгын хажууг хэвгийжүүлэн налуулах		175.03	Дотоод зардал		
Хэвгийжүүлсэн, нөхөн дүүргэсэн гадаргууг хэлбэржүүлэх, тэгшлэх тэгшилсэн талбайг дэвсгэржүүлэх	2.57	Дотоод зардал			
Барилга байгууламжинд өртсөн газрыг тэгшлэх.	Техникийн нөхөн сэргээлт	0.86	Дотоод зардал	Уурхайн хаалтын дараа хийгдэнэ.	
Шимт хөрсний овоолгоос шимт хөрс ухаж ачих, тээвэрлэн буулгаж, хучих ажил	Техникийн нөхөн сэргээлт	12.10	Дотоод зардал		
Ургамалжуулах ажлын зардал	Биологийн нөхөн сэргээлт		Дотоод зардал		
Цаашдын мониторинг хийх, орон нутагт үлдээх хөрөнгө	Биологийн нөхөн сэргээлт		Дотоод зардал	Уурхайн хаалтын дараа хийгдэнэ.	
Нийт зардал			4,000,000		

Зураг №17



4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

Уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт						
№	Дүйцүүлэх хамгаалах зорилт	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зарцуулсан төсөв	Биелэлт	Биелэлтийн хувь
1	Бэлчээрийн ургамлан нөмрөг бий болгох.	Техникийн нөхөн сэргээлт хийх	Сүхбаатар сум	4,000,000	Хайлаастын амын 1 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэн Сум орон нутагт хүлээлгэн өглөө.	100
Нийт зардал				4,000,000		

Зураг № 18-19 Нөхөн сэргээлт хийхээс өмнө болон хийж байх үе



Зураг №20 Нөхөн сэргээлт хийсний дараа



5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ

Төсөл хэрэгжих орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй болно.

№	Ажлын зорилго	Гүйцэтгэх ажил	Хамрах хүрээ	Зардал /сая, төг/	Биелэлт	Биелэлтийн хувь
1	Нөлөөллийн бүсийн айлд нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговор олгох.	Төлөвлөөгүй	-	-	-	-

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:



- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх
- Лицензтэй талбайгаас түүх соёлын дурсгалт олдворуудыг археологийн судалгаагаар илрүүлсэн боловч олборлолтын үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө.

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардал /мян,төг/	Биелэлт	Биелэлтийн хувь
Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Сүхбаатар аймаг	-	2022 онд уулын ажил зогссон ба одоогийн байдлаар олдвор илрээгүй байна.	-

7. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөгдсөн ажил	Зардал /төг/	Биелэлт	Биелэлтийн хувь
1	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Дотоод зардал	байгалийн аюулын үед ашиглах Гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулан мөрдөн ажиллаж байна.	100
2	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	Дотоод зардал	Гал унтраах багаж болон бусад шаардлагатай хэрэгслүүдийг галын буланд байршуулан нийт ажилтнуудад сургалт мэдээллийг зохион байгуулан ажиллаж байна.	100
3	Түймрийн хамгааллын хэрэгсэл багаж тоног төхөөрөмжөөр хангах.	Дотоод зардал	Гамшгаас хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	100
4	Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх	Дотоод зардал	Аваар устгах төлөвлөгөөг боловсруулан нийт ажилчидад танилцуулан ажиллаж байна.	100
5	Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах	Дотоод зардал	Анхны тусламжын хайрцагийг шаардлагатай газруудад байршуулан ажиллаж байна.	100
6	Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	Дотоод зардал	Ажилтан бүр нэг бүрийн хамгаалах хэрэгслийг тогтмол хэрэглэж байна.	100
7	Химийн хорт болон аюудтай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотой гарч болзошгүй ослын үед ажиллах, төлөвлөгөө боловсруулах заавар боловсруулж, мөрдөж ажиллах,	Дотоод зардал	Химийн ослоос урьдчилан сэргийлэх ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан мөрдөн ажиллаж байна. /Төлөвлөгөөг хавсралтаар оруулав/	100
8	Ажилтнуудын нэг бүрийн хамгаалах хэрэгсэл зэргийг ном дүрмийн дагуу мөрдсөнөөр сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлж болно.	Дотоод зардал	Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажлын байранд	100

Зураг № 24-25 Гамигаас хамгаалах төлөвлөгөө, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө



8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав.

- Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.
- Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн үзэл баримтлал, зүйл заалтыг үндэслэн боловсруулав.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зардал	Биелэлт	Биелэлтийн хувь
1	Ахуйн хог хаягдал	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	-	Үйл ажиллагааны явцад үүсэн бохирдсон хөрсийг тухай бүр цэвэрлэн, саармагжуулах талбайд байршуулан саармагжуулж байна.	100
2		Хаягдал бохир усыг “Ирвэс Инттрейд” ХХК-ийн худалдаалж буй “Тамир-Эм” био бэлдмэлээр сар тутам ариутгаж бие засах газар луу зайлуулах	500,000	Хаягдал бохир усыг бохир усны байгууламжид лаг задлагчийг дулааны улиралд тогтмол хийж байна.	100
3		Хатуу хог хаягдлыг зориулалтын битүүмжилсэн саванд хадгалж, байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын тогтоосон цэгт зайлуулж байх	Дотоод төсөв	Хог хаягдлын цэгт хадгалан сум орон нутгийн гэрээт байгууллагатай хамтран устгалыг хийж байна.	100
4	Үйлдвэрийн болон аюултай	Аюултай хог хаягдал хадгалах цэг байгуулж, ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах	Дотоод төсөв	Үйлдвэрээс уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг зориулалтын цэгт хадгалан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан сар бүр устгаж байна.	100
5		Аюултай хог хаягдлыг БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаалын дашуу зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан устгах, зайлуулах	Дотоод төсөв	Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан сар бүр устгаж байна.	100
6	Нийт		500,000		


Зураг № 26 Бохир задлагч



Зураг № 27 Хог хаягдал хуримтлуулах, устгах гэрээ



Зураг № 28 хог хаягдал хадгалах, цэг зөвшөөрөл



**9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт				
№	Төлөвлөгдсөн ажил	Зардал /мян.төг/	Биелэлт	Биелэлтийн хувь
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх.	20,000,000	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд Сүхбаатар сумын хойд хэсгээр салхины хамгаалалт бүхий зурвас байгуулан 1000 ш улиас тарьж хүлээлгэн өгөв.	100
2	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	3,000,000	Газрын төлөв байдлын судалгааг “Ашид ананда” ХХК-иар хийлгэв. Хянан баталгааг уурхайн ашиглалтын 4 газар дээр хийж гүйцэтгэв. /Тайланг хавсаргав	100
3	Гамшгийн эрдэлийн үнэлгээг хийлгэх	16,000,000	Гамшгийн эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд тайланг батлуулахаар холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн. /Үнэлгээг хавсаргав./	100
4	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	-	Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	100
5	Байгаль хамгаалах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр БОАЖЯ –нд хүргэж баталгаажуулах. /Тухайн жилийн БОМТ/	-	Холбогдох журмын дагуу төлөвлөгөө болон хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-р батлуулан ажиллаж байна.	100
6	Нийт	39,000,000		

Зураг № 29-30 Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛАГАТай ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2021.03.28 Дугаар ХАГ-2022/11 Баруун-Урл хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 179 дугаар тогтоолоор чөлөөт болгон баримтгаж ног талас Нутгийн захиргааны байгууллага, түүний төлөөлөгч Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Иридийг тусламь ашигласантай тусгай зөвшөөрлийн талбай замгардан сүм, түүний талбай Сүхбаатар сумын Засаг дарга Б.Батхурал нөгөө талас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл зөвшөөрч аж ахуй нэгж "Каскейд Майнинг ХХК" түүний төлөөлөгч гүйцэтгэх захирал М.Алтангэрэл (цаашдаа "Тусгай зөвшөөрөл зөвшөөрч" гэх) нар цаашид хамтад нь "Талууд" гэх дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр энэхүү гэрээг байгуулав.

1. Нөхцөл үндэслэл

1.1 Энэхүү гэрээ нь Сүхбаатар аймгийн Сүхбаат сумын 3-р багийн нутаг дэвсгэрт "Ашигт малтмалын тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл зөвшөөрч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, уурхайн байгууллагатай холбогдон арга бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд төр, хуулийн хэргийн түншлэлээр сайн дураар үзсэн дээр дамжсан хүчлэг, нийгмийн хариуцалгаа хүрээнд орон нутгийн захиргааны байгууллагатай байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахтай холбогдон харилцан зөвшилцсөн.

1.2 Энэхүү гэрээг холбоотой явцанд "Могойн урлан Чадан хууль", "Ашигт малтмалын тухай хууль", "Могойн урлан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль", "Харанг огуулагын тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомжор захируулна.

2. Талуудын харилцаа

2.1 Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум болон Тусгай зөвшөөрөл зөвшөөрчтэй хоорондын хамтын ажиллагааг энэхүү гэрээгээр зохицуулна.

2.2 Талууд нь уурхайн талбай харьяалагдах сүм, аймгийн нутгийн захиргааны байгууллага талуудаар дамжуулан орон нутгийн арга аргаар санал зөвлөж гэрээний төлөөлд тусгай аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаар хэлэлцэн баталсан 2022 оны Хамтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулна.

3. Аймаг, сумын Нутгийн захиргааны байгууллагын эрх үзрэг

3.1 Энэхүү гэрээний хүрээнд аймаг, сумын Засаг дарга нар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Хууль тогтоомжор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал ашиглах, тээвэрлэхийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн агууламдад дамжих ажиллана.

3.1.2 Үйлдвэр, уурхай, суурин түүний цамцгаан, дугаан, цэвэр, боовр усны шугам суурица байгуулах, зам тус, барилга байгууламжийн газар олголт, бусад шаардлагатай зөвшөөрлийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛАГАТай ТӨЛӨӨЛӨГЧ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА М.ИРИДЬ

СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.БАТХУРАЛ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЗӨВШӨӨРЧТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧ

"КАСКЕЙД МАЙНИНГ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ М.АЛТАНГЭРЭЛ



Зураг № 33 Гамигийн эрсдлийн үнэлгээ хийх ажлын гэрээ

